ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/55/-НА-СТА-ТШЗ**

## ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

## Агуулга

**Товчилсон үгийн жагсаалт** ........ 3
**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл** ........ 5
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан** ........ 5
**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** ........ 6
**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** ........ 7
**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** ........ 8
**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан** ........ 9
**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** ........ 10
**3. Аудитын тайлан** ........ 11
**3.1 Ерөнхий зүйл** ........ 11
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт** ........ 11
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ........ 12
**3.4 Материаллаг байдал** ........ 12
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга** ........ 12
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ........ 13
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг** ........ 15
**3.8 Аудитын гол асуудал** ........ 15
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 15
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 16
**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 16
**4. Аудитын илрүүлэлт** ........ 16
**4.1 Залруулсан алдаа** ........ 17
**4.3 Төлбөрийн акт** ........ 18
**4.4 Зөвлөмж** ........ 19

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ИТХТ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| НХМ | Нэг хэвийн маягт |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| СТСХ | Санхүү Төрийн сангийн хэлтэс |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/106

танай ________ -ны № ________ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ХАЖИДСҮРЭН ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

19020355

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэ | Эцсийн үлдэгд |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **28,252,894.64** | **25,709,689.64** |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 150,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 00.00 | 150,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 00.00 | 150,000.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 150,000.00 | 00.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 150,000.00 | 00.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 150,000.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 28,102,894.64 | 25,559,689.64 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,102,894.64 | 25,559,689.64 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,630,150.00 | 2,382,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,641,814.64 | 12,147,489.64 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,232,930.00 | 11,029,700.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **843,876,717.60** | **854,087,687.73** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 843,876,717.60 | 854,087,687.73 |
| **392** | **Биет хөрөнгө** | 794,787,717.60 | 804,998,687.73 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 929,234,536.84 | 940,034,536.84 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -328,039,162.29 | -344,142,454.41 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 147,976,041.00 | 179,429,576.84 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -86,429,840.57 | -99,527,678.21 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 135,894,473.60 | 141,942,873.60 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -133,550,781.46 | -135,219,781.42 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26,150,019.00 | 26,150,019.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -21,304,745.42 | -22,255,635.55 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 214,818,421.00 | 226,818,421.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -89,961,244.10 | -108,231,189.96 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 49,089,000.00 | 49,089,000.00 |
| 39301 | Програм хангамж | 628,917.00 | 628,917.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -628,917.00 | -628,917.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 49,089,000.00 | 49,089,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **872,129,612.24** | **879,797,377.37** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,433,915.37** | **1,506,043.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,433,915.37 | 1,506,043.00 |
| **413** | **Өглөг** | 1,433,915.37 | 1,506,043.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,433,915.37 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 1,506,043.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **870,695,696.87** | **878,291,334.37** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 870,695,696.87 | 878,291,334.37 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 371,408,675.13 | 371,408,675.13 |
| 51101 | Өмч: - төрийн | 371,408,675.13 | 371,408,675.13 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 227,691,922.01 | 235,287,559.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 227,691,922.01 | 227,691,922.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 7,595,637.50 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 271,595,099.73 | 271,595,099.73 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **872,129,612.24** | **879,797,377.37** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **531,611,880.85** | **516,821,556.84** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **90,784,670.00** | **54,668,935.84** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 90,784,670.00 | 54,668,935.84 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 90,784,670.00 | 54,668,935.84 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 90,784,670.00 | 54,668,935.84 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **440,827,210.85** | **462,152,621.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,116,249.85 | 41,812,321.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, | 6,200,000.00 | 18,091,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс | 2,500,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод | 4,888,046.00 | 20,842,321.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий | 14,528,203.85 | 2,879,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 412,710,961.00 | 420,340,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 412,710,961.00 | 420,340,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **524,383,829.07** | **509,225,919.34** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **497,985,240.78** | **491,438,496.34** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 469,944,727.96 | 472,256,131.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 232,186,378.39 | 240,219,111.36 |
| 210101 | Үндсэн цалин | 139,742,647.37 | 141,001,379.22 |
| 210102 | Нэмэгдэл | 34,859,609.61 | 35,975,732.14 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 57,584,121.41 | 63,242,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,257,510.04 | 31,885,307.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,218,128.85 | 23,120,798.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,259,845.30 | 2,359,105.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,807,896.25 | 1,838,566.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 451,949.04 | 440,096.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,519,690.60 | 4,126,739.81 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 71,643,769.60 | 73,452,079.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,171,009.00 | 8,982,369.00 |
| 210302 | Түлш, халаалт | 63,773,360.60 | 63,770,360.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 699,400.00 | 699,350.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,961,334.20 | 40,680,075.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,497,750.00 | 2,275,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,747,244.00 | 23,553,190.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 981,900.00 | 1,150,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 4,763,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,734,440.20 | 00.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 8,937,385.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 192,500.00 | 8,604,315.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 6,653,515.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 1,936,940.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 192,500.00 | 13,860.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,275,390.02 | 7,118,129.63 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 4,563,000.00 |
| 210602 | Тавилга | 4,690.30 | 14,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,270,699.72 | 2,541,129.63 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,939,400.00 | 2,103,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,939,400.00 | 2,103,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,943,385.51 | 805,214.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 12,298,973.75 | 234,856.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 320,000.00 | 320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 103,950.00 | 167,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 264,434.00 | 6,108.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 176,400.00 | 77,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 779,627.76 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 94,545,060.20 | 67,388,899.71 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,554,390.00 | 17,297,934.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 86,990,670.20 | 50,090,965.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28,040,512.82 | 19,182,364.47 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,383,800.00 | 3,498,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,794,800.00 | 3,498,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 589,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,** | 8,656,712.82 | 15,683,964.47 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,656,712.82 | 15,683,964.47 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **26,398,588.29** | **17,787,423.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 26,398,588.29 | 17,787,423.00 |
| 220001 | Барилга байгууламж | 7,398,588.29 | 00.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 19,000,000.00 | 17,787,423.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **7,228,051.78** | **7,595,637.50** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **7,228,051.78** | **7,595,637.50** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 371,408,675.13 | 271,860,453.73 | 218,999,516.23 | 00.00 | 862,268,645.09 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 265,354.00 | 00.00 | 265,354.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **371,408,675.13** | **271,860,453.73** | **219,264,870.23** | **00.00** | 862,533,999.09 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 15,884,764.60 | 00.00 | 15,884,764.60 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **371,408,675.13** | **271,595,100.73** | **227,691,922.01** | **00.00** | 870,695,697.87 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **371,408,675.13** | **271,595,100.73** | **227,691,922.01** | **00.00** | 870,695,697.87 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **371,408,675.13** | **271,595,100.73** | **227,691,922.01** | **00.00** | 870,695,697.87 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 7,595,637.50 | 00.00 | 7,595,637.50 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **371,408,675.13** | **271,595,100.73** | **235,287,559.51** | **00.00** | 878,291,335.37 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **440,827,210.85** | **462,152,621.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **440,827,210.85** | **462,152,621.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,116,249.85 | 41,812,321.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 6,200,000.00 | 18,091,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц | 2,500,000.00 | 01.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс | 4,888,046.00 | 20,842,321.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий | 14,528,203.85 | 2,879,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 412,710,961.00 | 420,340,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 412,710,961.00 | 420,340,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **421,827,210.85** | **431,824,221.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **421,827,210.85** | **431,824,221.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **393,378,528.03** | **412,641,856.53** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 232,186,378.39 | 241,653,026.73 |
| 210101 | Үндсэн цалин | 139,742,647.37 | 142,435,294.59 |
| 210102 | Нэмэгдэл | 34,859,609.61 | 35,975,732.14 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 57,584,121.41 | 63,242,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 31,257,510.04 | 31,885,307.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,218,128.85 | 23,120,798.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,259,845.30 | 2,359,105.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,807,896.25 | 1,838,566.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 451,949.04 | 440,096.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,519,690.60 | 4,126,739.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 71,640,769.60 | 73,452,079.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,171,009.00 | 8,982,369.00 |
| 210302 | Түлш, халаалт | 63,770,360.60 | 63,770,360.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 699,400.00 | 699,350.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,658,550.00 | 17,668,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,557,000.00 | 2,500,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,303,550.00 | 8,769,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 798,000.00 | 648,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 414,170.00 | 3,461,960.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 414,170.00 | 415,360.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,200,000.00 | 4,499,829.63 |
| 210604 | Урсгал засвар | 5,200,000.00 | 4,499,829.63 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,140,000.00 | 2,103,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,140,000.00 | 2,103,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,** | 13,611,885.00 | 1,068,462.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний | 12,747,101.00 | 370,336.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зөвлөгөө тогтоох | 320,000.00 | 320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 194,950.00 | 113,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 249,934.00 | 187,876.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,900.00 | 77,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,269,265.00 | 36,849,941.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,269,265.00 | 36,771,941.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,448,682.82** | **19,182,364.47** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,791,970.00 | 3,498,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 18,794,800.00 | 3,498,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 997,170.00 | 01.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох** | 8,656,712.82 | 15,683,964.47 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 8,656,712.82 | 15,683,964.47 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **19,000,000.00** | **30,328,400.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **19,000,000.00** | **30,328,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,000,000.00** | **30,328,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 19,000,000.00 | 30,328,400.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 19,000,000.00 | 21,280,000.00 |
| 226001 | Гадаад эх үүсвэрээр | 00.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-19,000,000.00** | **-30,328,400.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангила | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 427,374,300.00 | 420,340,300.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 399,504,300.00 | 399,060,300.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 396,005,900.00 | 382,721,379.53 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 242,332,800.00 | 241,653,026.73 |
| 210101 | Үндсэн цалин | 142,483,000.00 | 142,435,294.59 |
| 210102 | Нэмэгдэл | 36,607,800.00 | 35,975,732.14 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 63,242,000.00 | 63,242,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,714,800.00 | 31,885,307.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,021,600.00 | 23,120,798.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,423,300.00 | 2,359,105.69 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,938,600.00 | 1,838,566.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 484,700.00 | 440,096.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,846,600.00 | 4,126,739.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 81,232,800.00 | 73,452,079.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,172,700.00 | 8,982,369.00 |
| 210302 | Түлш, халаалт | 69,360,100.00 | 63,770,360.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700,000.00 | 699,350.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,119,100.00 | 16,968,250.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,501,300.00 | 2,500,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,069,800.00 | 8,069,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 798,000.00 | 648,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу | 5,750,000.00 | 5,750,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 415,400.00 | 415,360.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 415,400.00 | 415,360.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,500,000.00 | 4,499,829.63 |
| 210604 | Урсгал засвар | 4,500,000.00 | 4,499,829.63 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,779,600.00 | 2,103,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,779,600.00 | 2,103,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хуı** | 865,000.00 | 698,126.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 320,000.00 | 320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 195,000.00 | 113,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 187,876.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 77,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,046,400.0 | 11,046,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,046,400.00 | 11,046,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3498400.00 | 3498400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,498,400.00 | 3,498,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 3,498,400.00 | 3,498,400.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **27,870,000.00** | **21,280,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 27,870,000.00 | 21,280,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 27,870,000.00 | 21,280,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 427,374,300.00 | 420,340,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 427,374,300.00 | 420,340,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 427,374,300.00 | 420,340,300.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 25.00 | 25.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 09.00 | 09.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 13.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **23,358,046.00** | **41,812,321.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **23,358,046.00** | **38,968,877.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 23,358,046.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 700,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 700,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 3,046,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 3,046,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,200,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,200,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,888,046.00 | 370,336.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,888,046.00 | 370,336.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,270,000.00 | 34,851,941.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,270,000.00 | 34,773,941.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 78,000.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,843,444.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 23,358,046.00 | 41,812,321.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 23,358,046.00 | 41,812,321.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,941,796.15 | 18,091,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,500,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,888,046.00 | 20,842,321.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,028,203.85 | 2,879,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн хуулийг дээдлэн хүндэтгэж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг тасралтгүй чанартай хүргэж, төр засгийн бодлого шийдвэрийн дагуу орон нутгаа хөгжүүлэх, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах, сурч боловсрох, эрүүл аж төрөх нөхцөлөөр хангах үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2013 онд батлагдсан ба 2013 оноос хойш шинэчлэгдэн өөрчлөгдсөн хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартын өөрчлөлт хийгдээгүй байна.

Баянхангай сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны Б/25 дугаар тушаалаар дотоод хяналтын ажиллах журмыг баталсан боловч хяналт шалгалтын төлөвлөгөө, тайлан аудитад ирүүлээгүй болно. Засгийн газрын 2011 оны "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" батлах тухай 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн дотоод хяналтын ажлыг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд тус байгууллагын тусгай сангуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Мөн аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгээр зөвлөн туслах хяналт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхангай сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Баянхангай сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Баянхангай сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 421,827.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,327.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,061.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлаас тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг Баянхангай сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 431,824.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 6,477.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,181.9 мянган төгрөгөөр тогтоов. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 150.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал 120.0 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянхангай сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨТХ, Шилэн дансны тухай хуулиудыг мөрдлөг болгон Санхүүгийн тайланг “Payroll”, “Acolous” программыг ашиглан тайлагнасан байна.

***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 420,340.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 41,812.3 мянган төгрөгийг төвлөрүүлэн, мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 462,152.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд төсвийн хөрөнгөөр 9,048.4 мянган төгрөгийн, ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн галын автомашин 31,453.5 мянган төгрөгөөр, гэрэлтүүлэг 12,000.0 мянган төгрөгөөр, өрхийн тариалан бизнес хөгжил төрийн бус байгууллагын гүйцэтгэсэн худаг засвар

7,800.0 мянган төгрөгөөр нийт 51,253.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн ба данснаас хассан хөрөнгө байхгүй байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 49,498.3 мянган төгрөгийн, аймгийн ОБГ-аас 1,075.0 мянган төгрөгийн, ОНХС-ийн эх үүсвэрээс хийсэн хаягжуулалтын 2,340.4 мянган төгрөгийн орлогыг үнэ төлбөргүй ангиллаар бүртгэсэн байна.

***Авлага, өглөгийн талаар*:**

Жилийн эцсийн санхүүгийн тайланд урьдчилгаа 150.0 мянган төгрөгийн авлага, шатахууны 1,506.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Харилцагч бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

Санхүү байдлын тайлангаар мөнгөн хөрөнгө 00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материал 25,559.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 854,087.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 150.0 | 150.0 |
| Урьдчилгаа | 150.0 | - | (150.0) |
| Бараа материал | 28,102.9 | 25,559.7 | (2,543.2) |
| Үндсэн хөрөнгө | 843,876.7 | 854,087.7 | 10,211.0 |
| Нийт хөрөнгө | 872,129.6 | 879,797.4 | 7,667.8 |
| Өр төлбөр | 1,433.9 | 1,506.0 | 72.1 |
| Засгийн газрын оролцоо | 870,695.7 | 878,291.3 | 7,595.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 872,129.6 | 879,797.4 | 7,667.8 |

Бараа материалын дансны үлдэгдэл 25,559.7 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,543.2 мянган төгрөгөөр буурсан нь шатахуун, бусад хангамжийн материалын оны эхний үлдэгдэл зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 854,087.7 мянган төгрөг болж 10,211.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 60,301.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 878,291.3 мянган төгрөг болж 7,595.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд өгсөн саналыг шилэн дансны хуудсанд байршуулаагүй, мэдээлэл ирүүлээгүй тул харьцуулах боломжгүй байна.

Баянхангай сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 06 дугаар тогтоолоор ЗДТГ-ын төсвийг 424,328.0 мянган төгрөгөөр баталсан. Үүнээс 30.000.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс хөрөнгийн зардалд зарцуулахаар тусгасан. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны батлагдсан төсвийн шилжих үлдэгдлийн хөрөнгийн зардлаас 20,000.0 мянган төгрөгийг Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахад зарцуулахаар өөрчилсөн байна.

Баянхангай сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 06 дугаар тогтоолоор ЗДТГ-ын төсвийг 424,328.0 мянган төгрөгөөр баталсан дүнгээс аймгийн СТСХ-ийн зарцуулах эрхийг Сангийн Яамнаас нээлгэсэн 424,374.3 мянган төгрөгөөс 46.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байсанд төлөвлөгөөнд нийцүүлэн залруулга хийсэн болно.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 420,340.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаандаа 407,499.8 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу  зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 12,840.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 407,499.8 мянган төгрөг буюу 96,9 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд усны санхүүжилтэд 3,393.9 мянган төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар ковидын зардалд 6,000.0 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянган төгрөг, хагас жилийн малын тооны санхүүжилт  448.4 мянган төгрөг, нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хоёр аж ахуйн нэгжээс 3,000.0 мянган төгрөг, бэлчээрийн төлбөр 8,041.0 мянган төгрөг, УИХ-ын гишүүн болон иргэдээс 3,600.0 мянган төгрөг, оготно устгахад 4,000.0 мянган төгрөг, шүлхий өвчлөлд 3,500.0 мянган төгрөг, шатахуунд 700.0 мянган төгрөг,  салхи шуурганы хохирол барагдуулах зардалд 2,000.0 мянган төгрөг, гэрлийн шонгийн төлбөрт 950.0 мянган төгрөг, тэжээлийн үнэ 2,500.0 мянган төгрөг, ажлын зардал 500.0 мянган төгрөг, шатахууны түргэвчилсэн оношлуурын орлогоор 2,346.0 мянган төгрөг, өвсний борлуулалт 533.0 мянган төгрөг нийт 41,812.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна

Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас оготно устгахад 4,000.0 мянган төгрөг, шүлхий 4,200.0 мянган төгрөг, 3 худгийн засварт 3,000.0 мянган төгрөг, худгийн моторын авахад 3,122.0 мянган төгрөг, принтер авахад 915.0 мянган төгрөг,  тэжээл авахад 2,500.0 мянган төгрөг, өвсний фонд дээвэр засварт 2,450.0 мянган төгрөг, ковш автомашины засварт 2,096.0 мянган төгрөг, хогны машины засварт 2,285.0 мянган төгрөг, иргэдийн витаминжуултад 2,000.0 мянган төгрөг, сумын ЭМТ-д 1,000.0 мянган төгрөгийн эм, оношлуур, интернэт, ариутгалын бодисын үнэнд 5,000.0 мянган төгрөг, сумын Засаг даргын а/276 дугаар захирамжаар  шатахууны өрийг төлөхөд 3,381.9 мянган төгрөг, түргэвчилсэн оношлуурын үнэнд 1,800.0 мянган төгрөг, ариутгалын бодис, витаминд 470.6 мянган төгрөг,  гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 300.0 мянган төгрөг, хагас жилийн малын тооллогын зардалд

448.4 мянган төгрөг нийт 38,968.9 мянган төгрөг зарцуулж 2,843.46 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны Ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд сумын ИТХТ-ийн шийдвэрийн дагуу төсвийн шилжих үлдэгдлийн хөрөнгийн зардлаас 20,000.0 мянган төгрөгийг, УИХ-ын гишүүн болон иргэдээс 3,600.0 мянган төгрөг, аж ахуйн нэгжээс 2,000.0 мянган төгрөгийг хандиваар авч зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн аймгийн Засаг даргын А/72 дугаар захирамжаар 1,000.0 мянган төгрөг ирүүлснийг эм, эмнэлгийн хэрэгсэлд, мөн аймгийн Засаг даргын А/518 дугаар захирамжаар 5,000.0 мянган төгрөг ирүүлснийг сумын ЭМТ-д 1,000.0 мянган төгрөгийн эм, оношлуур, интернэт, ариутгалын бодисын үнэнд 5,000.0 мянган төгрөг зарцуулсан байна. Түргэвчилсэн оношлуурын орлогоор 2,346.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Баянхангай сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 06 дугаар тогтоолоор ЗДТГ-ын төсвийг 424,328.0 мянган төгрөгөөр баталсан дүнгээс аймгийн СТСХ-ийн зарцуулах эрхийг Сангийн Яамнаас нээлгэсэн 424,374.3 мянган төгрөгөөс 46.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байсанд төлөвлөгөөнд нийцүүлэн залруулга хийсэн болно.

Ньюремеди ХХК, Нэгүн арвижих ХХК, Мөнхийн тун ХХК, Тэгш-Анар ХХК зэрэг аж ахуйн нэгжид шилжүүлсэн 15,262.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийг данс бүртгэлд тусгаагүй байсныг эм боох материал дансанд 15,594.0 мянган төгрөгийг нэмж бүртгэн, бараа материалын данснаас сумын Эрүүл мэндийн төвд 15,586.0 мянган төгрөг, ЕБС-д 748.8 мянган төгрөг, СӨБ-д 139.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодис, сэлбэг, аж ахуйн материалын шилжүүлж залруулсан.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 17, огт байршуулаагүй 7 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд дараа жилийн төсвийн төсөл, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 12-р сард болон бүтэн жилээр, Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайланг болон Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланг бүтэн жилээр, Худалдан авах ажиллагааны тайлан, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан

мэдэгдлийг 12 дугаар сард байршуулж, мэдээлээгүй байна. Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөг байршуулаагүй.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг байршуулахдаа 8,10,12 дугаар сард хоосон гүйлгээ байхгүй гэж мэдээлсэн ба 25,356.4 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулах хэсэгт мэдээллийг 2,3, 5,6,7,8,10,12 дугаар сард байршуулаагүйгээс 351,555.3 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй ба өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх гэж заасны дагуу шийдвэрлэв.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг баримтлан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулж ажиллах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн №02/230 тоот албан бичгээр ирүүлсэн боловч тайлант оны мэдээллээс 17 мэдээллийг хугацаа хоцроож, 7 мэдээллийг огт байршуулаагүй тул албан шаардлага бичив.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянхангай сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна. Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 476,571.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 48,652.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,901.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 376,911.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 44,106.3 мянган төгрөгийн материаллаг бус зөрчилд зөвлөмж өгөв.

**4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга ирүүлээгүй, Санхүүгийн тайлангийн уялдаа, бүрэлдэхүүнийг шалгахад мөнгөн хөрөнгийн тодруулга, ерөнхий журнал, шалгах балансын гүйлгээ 30,614.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Санхүү байдлын тайланд бусад үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдлийг 700.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралт батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Мөнгөн гүйлгээний тайлангийн орлого, мөнгөн хөрөнгийн журналын дүнгээс 1,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, ОБГ-аас ирүүлсэн 1,075.0 мянган төгрөгийн орлогыг бүртгээгүй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн

Ньюремеди ХХК, Нэгүн арвижих ХХК, Мөнхийн тун ХХК, Тэгш-Анар ХХК зэрэг аж ахуйн нэгжид шилжүүлсэн 15,262.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн үнийг данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

**4.3 Төлбөрийн акт**

Өвсний тайлан тооцоо бодолтоор 6,220.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн орлого төвлөрүүлэхээс 533.0 мянган төгрөгийг нэмэлт дансны орлогоор төвлөрүүлж, 5,687.0 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн ““нийцсэн бөгөөд зохистой байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэж заасны дагуу шийдвэрлэв.

Баянхангай сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар 2 албан хаагчид үндсэн цалингийн 25% буюу 377.3 мянган төгрөг, Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн Б/14 дүгээр захирамжаар 1 албан хаагчид үндсэн цалингийн 25% -ийн буюу 261.4 мянган төгрөгийн, нийт 638.7 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн зардлаас олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын 1-д 2101 цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 210104 Урамшуулал гэдэгт ... нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын зардал хамаарахгүй гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэж заасны дагуу шийдвэрлэв.

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг шалгахад албан томилолтын хуудасгүйгээр 2 албан хаагчид 158.0 мянган төгрөгийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдөр олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” 5.1.3-д ”санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" бол төлбөрийн акт тогтоох гэж заасны дагуу шийдвэрлэв.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн төлбөрийн актын дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүйд тооцсон алданги 418.1 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй төсвөөс төлсөн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хуваарилалт", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" бол төлбөрийн акт тогтоох гэж заасны дагуу шийдвэрлэв.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Анхан шатны баримттай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 35,379.4 мянган төгрөгийн гүйлгээ тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулаагүй, Цагдаагийн болон хог тээврийн авто машин, ковшийн засварын зардалд 5,152.5 мянган төгрөгийн техникийн комиссын дүгнэлт, төсөв зарцуулах шийдвэргүй зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 "Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ..." гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. **<u>Өгсөн зөвлөмж</u>**:*

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан анхан шатны бүртгэлийн маягтыг зааврын дагуу бүрэн хөтөлж, хэвших ба худалдан авалт хийх бүрд НӨАТ-ийн цахим төлбөрийн баримтыг бүрдүүлж байх

***2. Анхан шатны баримттай холбоотой асуудал***

**2.1 <u>*Илрүүлэлт:*</u>**

Тооллогын комисс нь үндсэн хөрөнгийн болон бараа материалын үлдэгдлийг дутуу тоолсон, Сүрэн дээж ХХК-д 1,563.0 мянган төгрөгийг техникийн дүгнэлт, шийдвэргүйгээр автомашины урсгал засварт, Хоньт хайрхан ХХК-д материалын үнэнд гэж 2,011.4 мянган төгрөгийг шилжүүлсэн, хөрөнгө зарцуулах эрх бүхий албан тушаалтны шийдвэр байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” 5.1.5-д “хариуцлагатай байх” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

**2.2 *<u>Өгсөн зөвлөмж</u>*:**

Тооллогыг хууль тогтоомжийн дагуу чанартай, үнэн зөв хийж байх ба хөрөнгө, мөнгө зарцуулахдаа эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргуулж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр /

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | ЗДТГ | 10 | 476,571.9 | 3 | 48,652.4 | 4 | 6,901.8 | 1 | 376,911.4 | 2 | 44,106.3 |